



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын товч тайлан



Р.Лхагвадорж

Дундговь аймгийн ЗДТГ, Нийгмийн
бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар хорооны хурлыг хийж 11 заалт 2020 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа. 2020 оны салбар хорооны ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 97.2 хувьтай байна.



Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны төлөвлөгөөг 6 зорилт 14 заалттай төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгууллаа. Үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилт 82.3 хувьтай байна.



Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргаас сумдын Засаг даргатай байгуулдаг хамтран ажиллах гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жил бүр жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар заалт тусган жилийн эцэст хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

Хүйсийн тэнцвэрт байдлын судалгаа



Төрийн албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдлын тайланг жил бүр Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хороонд тайлагнадаг. Үүнд төрийн захиргааны болон нутгийн удирдлагын 30 байгууллагын 3008 албан хаагч, 15 сумын 574 албан хаагчын судалгааг гарган хүргүүллээ.




Удирдах албан хаагчдын дунд эмэгтэй албан хаагчдын эзлэх хувь

Дундговь аймгийн төрийн албан хаагчдын 316 албан хаагчид нь удирдах төрлийн албан хаагчид байсан ба тэдний 52%-ийг эмэгтэй албан хаагчид бүрдүүлж байна.

Удирдах албан хаагчдын хүйсийн харьцаа:



Насны бүлэг



Эдгээр удирдах төрлийн эмэгтэй албан хаагчдын 22% нь суманд үйл ажиллагаа явуулдаг газар, агентлагт харьяалагдан ажиллаж байна.



- Аймагт үйл ажиллагаа явуулдаг газар, агентлаг
- Суманд үйл ажиллагаа явуулдаг газар, агентлаг

Нийт удирдах төрлийн эмэгтэй албан хаагчдын 63% нь төрийн үйлчилгээний албанд, 22% нь төрийн захиргааны албанд ажиллаж байгаа бол 2% нь төрийн тусгай албанд ажиллаж байна.



Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалт


Хөдөлмөрийн мөлжлөг, ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтын аливаа хэлбэрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр заалтыг төрийн байгууллагууд хөдөлмөрийн дотоод журамд тусгах чиглэлийг өгч, хэрэгжилтэд хяналт тавьж байгууллагуудаас мэдээлэл авч ажиллалаа



Түр хамгаалах байрны үйл ажиллагаа:

Хүчирхийллийн хохирогчдыг аливаа гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тэдэнд нийгэм сэтгэл зүй, хууль эрх зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх зорилготой Түр хамгаалах байрны үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд анхаарч аймгийн ЗДТГ, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулж, энэ хүрээнд тог, цахилгаан, халаалт, зарим засварын ажлын зардал 1.6 сая төгрөгийг шийдвэрлэн өгч үйл ажиллагааг нь хэвийн явуулахад дэмжлэг үзүүлсэн байна.





Жендерийн эрх тэгш
байдлын талаарх
ойлголт, мэдлэгийг
дээшлүүлэх чиглэлээр
зохион байгуулсан
ажил

Жендэрийн дэд клуб

Орон нутгийн Жендерийн клубын үйл ажиллагааг идэхжүүлэх ажлын хүрээнд кофетой уулзалт зохион байгуулж, гишүүдийн оролцоотойгоор Сайнцагаан сумын Бор овооны энгэрт 200 мод суулгаж, усалгаа арчилгааг хийн сумын холбогдох ажилтанд хүлээлгэн өглөө.



“ОРОЛЦООНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ БОЛОН ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ” ЗҮҮН БҮСИЙН СУРГАЛТ



Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээлэл, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн албан хаагчид болон орон нутаг дахь төрийн бус байгууллагуудын чадавхыг дээшлүүлэх зорилгоор “Оролцооны хяналт шинжилгээ үнэлгээ болон мэдээлэл харилцааны чадавх бэхжүүлэх” зүүн бүсийн сургалтыг 2020 оны 8 дугаар 24-25-ны өдрүүдэд Дундговь аймагт зохион



ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ 16 ХОНОГИЙН АЯН



“Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 өдрийн аян”-ыг Ковид- 19 цар тахлын үед ахуйн хүрээний архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, тэр дундаа хүүхдийн хүчирхийллээс хамтдаа сэргийлж “Яг одоо хүчирхийллийг цэглэе” аянд нэгдэхийг бүх төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалж, ажилтан албан хаагчдад жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх мэдээ мэдээллийг хүргэлээ.

лого



ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ
16 ХОНОГИЙН АЯН

ХАЙР ӨВТГӨДӨГГҮЙ, ХҮЧИРХИЙЛЭЛГҮЙ БАЙЯ



15 суманд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөлийн арга хэмжээ зохион байгуулж 2495 иргэнийг хамруулсан байна.

“Хайр өвтөгдөггүй”, “Хүчирхийлэлгүй байя”, “Яг одоо” аянуудыг цахимаар зохион байгуулж 900 гаруй иргэн хандалт хийсэн байна.



АХИСАН ТҮВШНИЙ ЖЕНДЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ ЦАХИМ СУРГАЛТ



Засаг даргын эрхлэх хүрээний агентлагуудын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд МЕРИТ төслийн боловсруулсан “Ахисан түвшний Жендерийн дүн шинжилгээ” цахим сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан.



АНХААРАЛТАВЬСАНД БАЯРЛАЛАА



Дундговь аймгийн ЗДТГ, Нийгмийн бодлогын
хэлтсийн мэргэжилтэн Р.Лхагвадорж



99019320



Lhagwaa0617@yahoo.com